



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 98

Сэргээнтэй

**Орон нутгийн өмчих хуулийн
этгээдийн Төлөөлөн удирдах
зөвлөлийг батлах тухай**

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ Нь:

1. Орон нутгийн өмчих "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК, "Гэр булийн ордон" ОНӨҮГ, "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлдөл үүрэг БОЛГОХ нь:

2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулах.

2.2. Гүйцэтгэх захирлын эрх, хэм хэмжээг дүрэм, ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж, өмч хөрөнгө, санхүүгийн нөөц, зарцуулах зардлын дээд хязгаар эрхийг тогтоон хяналт тавин ажиллах.

2.3. Аж ахуйн нэгжийн зорилтот түвшний хэрэгжилт, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашиг, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар дээшлүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, өр авлага бууруулах талаар гүйцэтгэх захирлын хийж гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүрийн хагас, бүтэн жилээр хэлэлцэн, дүгнэлт гаргаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанц хүргүүлж байх.

3. Орон нутгийн өмчих хуулийн этгээдүүдийн Төлөөлөн удирдах зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг хагас, бүтэн жилээр дүгнэж, тайланг жил бүрийн IY улиралд баатаран аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 148 дугаар тогтооолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

П.ПУРЭВЛХАГВА

